



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/107

Чойбалсан

Г Тусгай зөвшөөрөлд байршлын өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтууд, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 400 дугаар тушаал, “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын 2022 оны гуравдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Халгайн үндэс” ХХК-ийн “Халгай” эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд байршлын өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхийг “Халгайн үндэс” ХХК-ийн захиралд үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажлын алба (Ч.Оюунаа), Мэргэжлийн хяналтын газар (Д.Мөнхтуяа)-т тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Э.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

0101 1917

Аймгийн Засаг даргын 2022 оны
12 дугаар сарын 16-ны өдрийн
1707 дугаар захирамжийн хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТ
ХИЙЛГЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА

№	Хуулийн этгээдийн нэр	Оноосон нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Үйл ажиллгааны чиглэл	Хуучин байршлын хаяг	Шинэ байршлын хаяг
1	"Халгайн үндэс" ХХК	"Халгай" эмийн сан	ЭСХ- 20/09/3919	Эм барих, худалдах /2 дугаар зэрэглэл/	Дашбалбар сум, Улз баг, Цагаан дэвийн 405 тоот	Дашбалбар сум, Улз баг, Цагаан дэвийн 405 тоотын хажууд шинэ барилга